

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 239 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-ийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1.2.24 дэх заалт:

“1.2.24.“мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл” гэж 50 куб.см-ээс ихгүй ажлын багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүртэй, эсхүл 0.25 кВт-аас 4 кВт хүртэл чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй, техникийн дээд хурд нь цагт 50 км-ээс ихгүй, хоёр, эсхүл хэд хэдэн дугуйтай тээврийн хэрэгслийг;

2/25.3 дахь хэсэг:

25.3.Унадаг дугуйг 10 хүртэлх насны хүүхэд харгалзах хүнтэйгээр зөвхөн явган хүний зам дээр, харин 10-аас 16 хүртэлх насны хүүхэд явган хүний зам болон түүн дээр тэмдэглэгдсэн унадаг дугуйг дугуйн замаар унаж хөдөлгөөнд оролцож болно. 18 нас хүрээгүй бол мопед жолоодож замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно.;

3/25.4 дэх хэсэг:

25.4.Унадаг дугуйг 16-аас, мопедыг 18-аас дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцохдоо унадаг дугуйн зам буюу унадаг дугуйн эгнээгээр явах бөгөөд дараах тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талын захаар байрлан явж болно.;

4/27.2 дахь хэсгийн “а” заалт:

27.2.а/10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр явганаар болон унадаг дугуй унаж замын хөдөлгөөнд оролцуулахгүй, түүнчлэн 18 нас хүртэлх хүүхдээр мопед жолоодуулахгүй байх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1-д “Монгол Улсын иргэн “амьд явах”, 2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах” эрхтэй гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Замын хөдөлгөөний дүрмийг Засгийн газар батална” гэж тус тус хуульчилсан.

Нийслэлийн Автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төвд мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч 8 аж ахуй нэгж байгууллагын 13 загварын 33658 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа ба иргэдийн гар дээрх болон өдөрт замын хөдөлгөөнд оролцож байгаа тухайн төрлийн тээврийн хэрэгслийн тоог тодорхойлох боломжгүй талаар мэдээлэлтэй байна.

Энэ төрлийн тээврийн хэрэгслийн тоо 2022 оноос эхлэн нэмэгдэж, үүнээс үүдэлтэй осол гэмтлийн тохиолдол огцом өссөн. Эрүүл мэндийн байгууллагаас Улсын хэмжээнд 2024 онд ослын тохиолдол 446 бүртгэгдсэн бол 2025 онд 2792 болж 6 дахин, 2026 оны эхний 5 сарын байдлаар 814 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 дахин тус тус өссөн үзүүлэлтэй байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэд, ялангуяа 18 нас хүрээгүй хүүхэд, залуучууд шинэ төрлийн бичил цахилгаан тээврийн хэрэгслүүд, түүний дотор цахилгаан дугуй /суррон/, цахилгаан скүүтерээр замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдэж байна. Мөн хүн амын хэт төвлөрөл, хотжилт, авто замын түгжрэлээс үүдэлтэйгээр Нийслэл Улаанбаатар хотод нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, скүүтер түрээсийн шинэ төрлийн үйлчилгээ бий болж, иргэдийн хэрэглээг өсгөж байна. Гэвч үүнийг дагаад цахилгаан дугуй /суррон/, цахилгаан скүүтерээс унаж бэртэх, явган зорчигч, автомашин, унадаг дугуй, мотоциклтэй мөргөлдөж зам тээврийн осол гэмтэлд өртөх, иргэдийн аюулгүй, тайван зорчих эрхэд нөлөөлөх, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах явдал ихэссэн.

Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндэс, журмыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмээр зохицуулж байгаа хэдий ч энэхүү хууль болон дүрмийн хүрээнд дээрх шинэ төрлийн бичил цахилгаан тээврийн хэрэгсэл /цахилгаан дугуй, скүүтер г.м/-ийн тээврийн хэрэгслийн ангилал, нэршил тодорхойгүйгээс тухайн тээврийн хэрэгслийг жолоодох насны хязгаарын ойлголтын зөрөөтэй байдал үүссэн, тээврийн хэрэгсэлд тавих техникийн ерөнхий шаардлага байхгүй, тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцогчийн үүрэг, хариуцлага, мөн нийтийн хэрэгцээний цахилгаан скүүтер түрээсийн үйлчилгээ үзүүлэгчид хяналт тавих эрх зүйн орчин байхгүй зэрэг зохицуулалтгүй байдлыг харгалзан Монгол Улсын Их Хурлын 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн чуулганаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ

үзүүлэх, түүнд тавих хяналт, зохицуулалт, оролцогчийн эрх, үүрэг зэргийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг эцэслэн баталсан.

Дээрх хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм”-д заасан мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн нэр томьёо, хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж хөдөлгөөнд оролцогчийн насны хязгаарыг тогтоох, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд дээр дурдсан нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”-д өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл, унадаг дугуйг 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй, 10-аас 16 хүртэлх насны хүүхэд явган хүний зам болон түүн дээр тэмдэглэгдсэн унадаг дугуйн замаар унаж хөдөлгөөнд хөдөлгөөнд оролцох, мопедыг 18-аас дээш насны хүн жолоодох эрхтэй байхаар өөрчлөн найруулахаар тусгасан.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд өөрчлөлт орсноор замын хөдөлгөөнд оролцогч бусад этгээд, явган зорчигчийн эрх, амь нас, эрүүл аюулгүй байдал хангагдаж, мопед түүний төрөлд хамаарах шинэ төрлийн бичил цахилгаан тээврийн хэрэгслүүд болох цахилгаан дугуй, цахилгаан скүүтер, хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгслийн ангилал, нэршил тодорхойлолт болон тус тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцогч жолоочийн эрх, үүрэг, хариуцлага тодорхой болсноор энэ төрлийн тээврийн хэрэгсэлтэй холбоотой замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэхээс гадна улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүйг дурдах нь зүйтэй.

---oOo---